

ТАНИЛЦУУЛГА

*Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
хуулийн төслийн талаар*

Монгол Улсын Их Хурал аж үйлдвэрийн үндсэн объект болох барааны тэмдэг, газар зүйн заалтад эрхийн хамгаалалт олгож, эдийн засгийн эргэлтэнд оруулах нөхцөлийг хангах зорилгоор 2003 онд Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийг батлан мөрдүүлж, улмаар Барааны тэмдгийн хуулийн тухай Сингапурын гэрээ болон нийгэм, эдийн засгийн харилцааны шинэчлэлтэй уялдуулан 2010 онд шинэчилсэн найруулсан.

Гэвч хуулийг хэрэгжүүлэх явцад зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх, хэрэглэхэд хүндрэл гарах болсон төдийгүй барааны тэмдгийн эрхийн хамгаалалтын үйл ажиллагаа бүрэн цахимжсантай холбогдуулан барааны тэмдгийн мэдүүлэг гаргах, мэдүүлэгт шүүлт хийх, бүртгэлд бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, хэвлэх зэрэг үйл ажиллагааг Монгол Улсын нэгдэн орсон Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенц, Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр, Барааны тэмдгийн хуулийн тухай Сингапурын гэрээ зэрэг олон улсын гэрээ хэлэлцээрт нийцүүлэх, давамгайлах огнооны эрхийн зохицуулалт, барааны тэмдэг, газар зүйн заалтыг ашиглах хугацаанаас хамааруулан хүчингүй болгох нөхцөлийг тодорхойлох, улсын бүртгэлд бүртгэгдсэн хуулийн этгээдийн нэртэй давхацсан барааны тэмдгийг бүртгэхгүй байх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгах шаардлагатай болсон.

Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд олон улсын гэрээ, конвенц, Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжид нийцүүлэн доор дурдсан зохицуулалтыг тусган боловсрууллаа. Үүнд:

1.Хуулиар тодорхойлсон газар зүйн заалт, хамтын тэмдэг нэр томьёог Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээрт заасантай нийцүүлэн шинэчлэн тодорхойлсон.

2.Хуулиар тогтоосон барааны тэмдгийг бүртгэхээс татгалзах үндэслэлд улсын бүртгэлд бүртгэгдсэн хуулийн этгээдийн нэртэй давхацсан барааны тэмдгийг бүртгэхгүй байх нөхцөлийг нэмж тусгасан.

3.Хуулийн этгээдийн нэрийн сангаас шүүлт хийхэд Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.9, 12.12-т заасан мэдээлэл солилцох журмыг баримтлахаар тусгаж, улсын бүртгэлийн мэдээллийн сангаас шүүлт хийх боломжийг бүрдүүлсэн.

4.Барааны тэмдгийн шүүлтийг чанаржуулах, барааны тэмдэг, газар зүйн заалт бүртгэгдсэний дараа маргаан гарах асуудлаас урьдчилан сэргийлэх зорилгоор мэдүүлгийн шүүлтийн шатанд гуравдагч этгээдээс эсэргүүцэл гаргах боломжийг бүрдүүлсэн.

5.Монгол Улсын нэгдэн орсон Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенци, Худалдаанд хамаарах Оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээрт

нийцүүлэн барааны тэмдэг эзэмшигч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр барааны тэмдгийг 5 жилийн турш ашиглаагүй бол хүчингүй болгох тухай зохицуулалтыг тусгасан.

6.Барааны тэмдэг эзэмшигч өөрийн нэр, хаяг өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр хүсэлт гарган барааны тэмдгийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулах шаардлагыг үүрэгжүүлсэн.

7.Газар зүйн заалтын хэрэглэгч өөрийн нэр, хаяг өөрчлөгдсөн, эсхүл эрхээ шилжүүлсэн тохиолдолд тухай бүр хүсэлт гарган газар зүйн заалтын улсын бүртгэлд өөрчлөлт оруулах шаардлагыг үүрэгжүүлсэн.

8.Бүртгэгдсэн барааны тэмдгийн анхдагч огнооноос өмнө уг барааны тэмдэгтэй адил тэмдгийг адил бараа, үйлчилгээнд шударгаар хэрэглэж байсан этгээдийн хувьд үйлчлэх онцгой эрхийн зохицуулалтыг нэмж тусгасан.

9.Барааны тэмдгийг нийтэд түгээмэл болсонд тооцоход үйлчилгээний хураамж төлөхөөр зохицуулсан.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ